



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026. 07. 02 № 31-1/75
танай _____-ны № _____-т


Асуудал зөвшилцөх тухай

"Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын богино хугацааны зорчигчдын тээврийн хэрэгсэл жолоодох болон жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох тухай хэлэлцээр"-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 38 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264003112

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 27 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“9.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын богино хугацааны зорчигчдын тээврийн хэрэгсэл жолоодох болон жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох тухай хэлэлцээр”-ийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын богино хугацааны зорчигчдын тээврийн хэрэгсэл жолоодох болон жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох тухай хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын богино хугацааны зорчигчдын тээврийн хэрэгсэл жолоодох болон жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох тухай хэлэлцээр”-ийн тухай

Монгол Улсын иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аяллын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан монголчууд ихээр зорчиж, амьдарч, мөн ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр гэрээ хэлэлцээр байгуулах асуудалд тус яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

Дээрх асуудлын Бүгд Найрамдах Солонгос Улстай “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын богино хугацааны зорчигчдын тээврийн хэрэгсэл жолоодох болон жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох тухай хэлэлцээр”-ийг байгуулахаар төслийг тохиролцоод байна.

Энэхүү хэлэлцээрийн зорилго нь богино хугацааны зорчигч Хэлэлцэн тохирогч нэг талын иргэн өөрийн олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох, мөн Хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрт нэг (1) жилээс дээш хугацаагаар оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэний үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхэд оршиж байна.

Хэлэлцээр нь нийт 10 зүйл, хавсралтуудаас бүрдэж байгаа бөгөөд богино хугацааны зорчигчид нөгөө талын нутаг дэвсгэрт орж ирсэн өдрөөс эхлэн нэг (1) жил хүртэлх хугацаанд өөрийн үнэмлэхэд заасан тухайн ангиллын хүрээнд хамаарах тээврийн хэрэгслийг олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээрээ жолоодох эрхийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Түүнчлэн аль нэг талын нутаг дэвсгэрт нэг (1) жил буюу түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор оршин сууж буй, 18 насанд хүрсэн нөгөө талын иргэд онолын болон жолоодлогын нэмэлт шалгалтгүйгээр, дүйцүүлэх хүснэгтийн дагуу хүсэлтээ гарган, өөрсдийн үндэсний жолоодох эрхийн үнэмлэхээ солиулахтай холбоотой харилцааг зохицуулсан. Энэ хүрээнд хүсэлт гаргагч нь өөрийн улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн эх хувийг, хүлээн авагч талын албан ёсны хэлээрх эсхүл англи хэл дээрх баталгаат орчуулгын хамт эрх бүхий байгууллагад нь хүлээлгэн өгнө. Хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий байгууллага өөрийн дотоодын хуульд заасан журмын дагуу холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэх юм.

Хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудаар Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний цагдаагийн газар ажиллах юм.

Энэхүү хэлэлцээрийн байгуулснаар хоёр улсын иргэдийн нөгөө талын нутаг дэвсгэрт богино хугацаагаар зорчих, хууль ёсоор оршин суух хугацаандаа жолоодох эрхээ баталгаажуулах, түүнчлэн үндэсний жолоодох эрхийн үнэмлэхээ солиулах

чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой болох юм.

Одоогоор Бүгд Найрамдах Солонгос Улсад манай улсын 60 гаруй мянган иргэн оршин сууж, суралцаж, хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд хоёр орны хооронд аялал жуулчлал, бизнесийн зорилгоор харилцан зорчих иргэдийн тоо тасралтгүй өсөж байгаа статистик мэдээлэл байна. Тухайлбал Гадаад хэргийн яамны Консулын газраас 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн мэдээллээр БНСУ-д богино хугацаанд зорчсон Монгол иргэдийн тоо 2022 онд 67,146, 2023 онд 141,638, 2024 онд 150,201, 2025 онд 161,755 болж жил бүр өссөн байна. Үүний зэрэгцээ Монгол Улсад зорчсон БНСУ-ын иргэдийн тоо 2022 онд 52,793 байсан бол 2025 онд 162,971 болж мөн адил тогтвортой өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцын гишүүн бус орноос олгогдсон жолоочийн болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр Монгол Улсын нутаг дэвсгэр механикжсан тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно” гэж заасан бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улс нь энэхүү конвенцыг соёрхон баталж нэгдэн ороогүй байна.

Иймд Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “дотоодын хууль тогтоомжоос өөр журам тогтоосон гэрээг заавал соёрхон батална” гэж заасны дагуу энэхүү хэлэлцээр нь заавал соёрхон батлах гэрээнд хамаарч байгаа холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан танилцуулж байна.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД БОГИНО ХУГАЦААНЫ ЗОРЧИГЧДЫН
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ БОЛОН ЖОЛООДОХ ЭРХИЙН
ҮНЭМЛЭХИЙГ ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, СОЛИЛЦОХ ТУХАЙ
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар (цаашид дангаар нь “Хэлэлцэн тохирогч тал”, хамтад нь “Хэлэлцэн тохирогч талууд” гэх),

Хэлэлцэн тохирогч талуудын 2021 онд тогтоосон Стратегийн түншлэлийн харилцааг иш үндэс болгон,

Хоёр талт харилцааны үндсэн тулгуур болох хоёр улсын иргэд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг дэмжихийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

Хоёр улсын иргэдийн нийтлэг ашиг сонирхлын үүднээс замын хөдөлгөөн ба түүний аюулгүй байдлын талаарх хоёрт талт харилцааг бэхжүүлж, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг эрмэлзэж,

Өөрийн нутаг дэвсгэр дээрх замын хөдөлгөөнийг саадгүй байлгах, Хэлэлцэн тохирогч нэг талын богино хугацааны зорчигч өөрийн олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодохыг харилцан хүлээн зөвшөөрөх, мөн Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагаас олгосон үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор,


Энэхүү хэлэлцээрийг дараах байдлаар тохиролцов:

1 дүгээр зүйл
Зорилго

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь богино хугацааны зорчигч Хэлэлцэн тохирогч нэг талын иргэн өөрийн олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох, мөн Хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрт нэг (1) жилээс дээш хугацаагаар оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэний үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхэд оршино.

2 дугаар зүйл

Богино хугацааны зорчигч Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох



1.Хэлэлцэн тохирогч талууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас олгосон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодохдоо дараах журмыг баримтална:

(a) Монгол Улсад, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас олгосон олон улсын жолоодох эрхийн үнэмлэх эзэмшигч Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдэд Хавсралт Б-д заасан тухайн үнэмлэхийн ангилалд хамаарах тээврийн хэрэгсэл жолоодохыг зөвшөөрнө;

(b) Бүгд Найрамдах Солонгос Улсад, Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас олгосон олон улсын жолоодох эрхийн үнэмлэх эзэмшигч Монгол Улсын иргэдэд Хавсралт А-д заасан тухайн зөвшөөрлийн ангилалд хамаарах тээврийн хэрэгсэл жолоодохыг зөвшөөрнө.

2.Жолоодохыг зөвшөөрөх тээврийн хэрэгслийн төрөл нь олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр тодорхойлогдоно.

3.Хэлэлцэн тохирогч нэг талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт орж ирсэн өдрөөс эхлэн нэг (1) жил хүртэлх хугацаанд оршин суухдаа эзэмшиж буй олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодох бөгөөд Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг паспортын хамт түүнд шалгуулна.


3 дугаар зүйл

Үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг солилцох

1.Үндэсний жолоодох эрхийн үнэмлэх солилцох ажиллагааг саадгүй явуулах зорилгоор Хэлэлцэн тохирогч талууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас олгосон, хүчин төгөлдөр үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрнө. Үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг энэхүү Хэлэлцээрийн Хавсралт С-д заасан Дүйцүүлэх хүснэгтийн дагуу солилцоно.

2.Энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу, Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэг (1) жилээс дээш хугацаагаар хууль ёсоор оршин суугаа, арван найман (18)-аас доошгүй настай, хүчин төгөлдөр үндэсний жолоодох эрхийн үнэмлэх эзэмшигч Хэлэлцэн тохирогч нэг талын иргэн нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодохыг хүсвэл зохих хүсэлт гарган, хүчин төгөлдөр үндэсний жолоодох эрхийн үнэмлэх (түр болон сургалтын үнэмлэхээс бусад)-ээ Хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагаар солиулна.

3.Үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг солиход өргөдөл гаргагчаас тээврийн хэрэгсэл жолоодох ур чадварыг баталгаажуулах онолын болон жолоодлогын шалгалт өгөхийг шаардахгүй. Өргөдөл гаргагч нь жолоодох эрхийн үнэмлэх сольж буй Хэлэлцэн тохирогч талын холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шаардлагатай төлбөр, хураамжийг төлж, эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн байна.



4.Энэхүү Хэлэлцээр нь зөвхөн Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагаас анхлан олгосон үндэсний жолоодох эрхийн үнэмлэхэд хамаарах бөгөөд гуравдагч улсаас олгосон үнэмлэхийг солиулан авсан үндэсний жолоодох эрхийн үнэмлэхэд хамаарахгүй.

5.Энэхүү зүйлийн 3 дахь хэсэг нь нас, эрүүл мэнд, эсхүл сэтгэцийн байдалд үндэслэн жолоодох эрхийг хязгаарлахтай холбоотой Хэлэлцэн тохирогч талуудын дотоодын хууль тогтоомжид нөлөөлөхгүй.

4 дүгээр зүйл **Солилцох журам**

1.Үндэсний жолоодох эрхийн үнэмлэх солиулах хүсэлтийг хянан шийдвэрлүүлэх зорилгоор хүсэлт гаргагч нь өөрийн улсын эрх бүхий байгууллагаас олгосон үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн эх хувийг, хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын албан ёсны хэлээрх, эсхүл англи хэлээрх баталгаат орчуулгын хамт хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.

2.Үндэсний жолоодох эрхийн үнэмлэх солих ажлыг гүйцэтгэж буй Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага нь холбогдох дотоодын хууль тогтоомжийн дагуу нэмэлт баримт бичиг, түүн дотор 1961 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцын дагуу үндэсний жолоодох эрхийн үнэмлэх солиулах хүсэлт гаргахаас өмнө олгосон, 1 (нэг) жилийн хугацаа өнгөрөөгүй, Хэлэлцэн тохирогч нөгөө талын холбогдох байгууллагаас олгосон Апостиль гэрчилгээг нэмж шаардаж болно.


3.Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд жолоочийн бүртгэл болон захиргааны үйл ажиллагаатай холбоотой өөрсдийн дотоодын хууль тогтоомжийг мөрдөж болно.

5 дугаар зүйл **Үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг магадлах**

1.Солихоор ирүүлсэн үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй байдал болон/эсхүл үнэн зөв эсэхэд эргэлзээ үүссэн тохиолдолд үнэмлэх солих ажлыг гүйцэтгэж буй Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага нь тухайн үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй байдал болон/эсхүл үнэн зөв эсэхийг магадлах тухай хүсэлтийг Хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагад бичгээр гаргаж болно.

2.Факс, цахим шуудан эсхүл бусад цахим хэрэгслээр дамжуулан илгээсэн хүсэлтийг бичгээр гаргасанд тооцно.

3.Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага нь хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагад тухайн үндэсний



жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй байдал болон/эсхүл үнэн зөв эсэх талаарх мэдээллийг нэн даруй хүргүүлнэ.

4. Шаардлагатай бол магадлагаа хийх зорилгоор хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага нь хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагаас нэмэлт мэдээлэл шаардаж болно.

6 дугаар зүйл **Эрх бүхий байгууллагууд**

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч талууд нь дараах эрх бүхий байгууллагыг томилов:

(a) Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Цагдаагийн Ерөнхий Газар;

(b) Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрыг төлөөлж, Солонгосын Үндэсний цагдаагийн газар.

2. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохирогч талууд дипломат шугамаар дараах мэдээлэл, баримт бичгийг харилцан солилцоно:

(a) өөрсдийн эрх бүхий байгууллагуудын нэр, хаяг, утас, факсын дугаар болон цахим шуудангийн хаяг;


(b) энэхүү Хэлэлцээрт хамаарах олон улсын жолоодох эрхийн үнэмлэх болон үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн загвар; үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө талын албан ёсны хэл болон англи хэлээр орчуулсан баталгаат орчуулга.

3. Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн үндэсний жолоодох эрхийн үнэмлэхэд орсон аливаа өөрчлөлт (жишээлбэл, загварт орсон өөрчлөлт), энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтэд нөлөөлж болохуйц дотоодын хууль тогтоомжийн аливаа өөрчлөлт, мөн эрх бүхий байгууллагуудын холбоо барих мэдээлэлд орсон өөрчлөлтийг тус тус дипломат шугамаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

7 дугаар зүйл **Харилцаа холбоо**

Энэхүү Хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллага хооронд, мөн Хэлэлцэн тохирогч талуудын хооронд дипломат шугамаар хийгдэх харилцаа холбоог бичгээр үйлдэх бөгөөд түүнд Хэлэлцэн тохирогч нөгөө талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээрх орчуулгыг хавсаргана.

8 дугаар зүйл **Бусад гэрээний үйлчлэл**



Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч талуудын нэгдэн орсон бусад олон улсын гэрээнээс үүсэх эрх, үүргийг хөндөхгүй.

9 дүгээр зүйл
Зөвлөлдөх

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч талуудын хооронд үүссэн ойлголтын зөрүүг Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд зөвлөлдөж шийдвэрлэнэ. Хэрэв ойлголтын зөрүүг эрх бүхий байгууллагууд зөвлөлдөж шийдвэрлэж чадахгүй бол дипломат шугамаар шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл
Төгсгөлийн заалт

1. Хүчин төгөлдөр болгохтой холбоотой үндэсний хууль тогтоомжийн дагуу дотоодын процедураа хангасан тухай харилцан бие биедээ дипломат шугамаар бичгээр мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаа дахь сарын эхний өдрөөс эхлэн энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

2. Энэхүү Хэлэлцээр нь тодорхойгүй хугацаагаар хүчин төгөлдөр байна. Хэлэлцэн тохирогч аль ч тал дипломат шугамаар, бичгээр мэдэгдэл өгч энэхүү Хэлэлцээрийг цуцалж болно. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч нөгөө тал цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ер (90) дэх өдөр дуусгавар болно.

3. Хэлэлцэн тохирогч талуудын харилцан тохиролцсоноор энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлтийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмын дагуу хүчин төгөлдөр болох протоколоор албажуулах бөгөөд тэдгээр нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

ДЭЭРХИЙГ ГЭРЧИЛЖ, тус тусын Засгийн газраас зохих ёсоор бүрэн эрх олгогдсон доор гарын үсэг зурсан Төлөөлөгчид энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

2026 оны 07 дугаар сарын ____-ний өдөр Улаанбаатар хотноо монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарын зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх хувийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

Монгол Улсын Гадаад харилцааны яам АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН
Гарын үсэг /Signature/ <i>OB</i>
2026 оны 6 сарын 24 өдөр Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia OFFICIAL TRANSLATION

Хавсралт А
Монгол Улсын Засгийн газраас олгодог Олон улсын жолоодох эрхийн
үнэмлэх дэх тээврийн хэрэгслийн ангилал

Ангилал	Тээврийн хэрэгслийн ангилал
А	Мотоцикл (Дотоод шаталтат хөдөлгүүрийн ажлын багтаамж нь 50 см ³ -ээс их, эсхүл цахилгаан хөдөлгүүрийн нэрлэсэн чадал нь 4 кВт-аас их, зохион бүтээлтийн дээд хурд нь 50 км/ц-аас дээш байх хоёр дугуйт механикжсан тээврийн хэрэгсэл, үүнд мопед хамаарна), 18 ба түүнээс дээш нас
В	Жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин (Бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй), 18 ба түүнээс дээш нас
С1	Бүх жин нь 7500 кг-аас ихгүй С ангиллын автомашин (Бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй), 18 ба түүнээс дээш нас
С	Бүх жин нь 3500 кг-аас их ачааны автомашин (D ангилалд хамаарахаас бусад, бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй бүрэлдэхүүн хамаарна), 18 ба түүнээс дээш нас
D1	Жолоочоос гадна зорчигчийн суудал нь 16-аас илүүгүй D ангиллын автомашин (Бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй бүрэлдэхүүн хамаарна), 21 ба түүнээс дээш нас
D	Жолоочоос гадна зорчигч тээвэрлэхэд зориулсан наймаас дээш суудалтай автомашин (Бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй бүрэлдэхүүн хамаарна), 21 ба түүнээс дээш нас
BE	Бүх жин нь 750 кг-аас их чиргүүлтэй холбосон В ангиллын автомашин, 18 ба түүнээс дээш нас
C1E	Бүх жин нь 750 кг-аас их чиргүүлтэй холбосон С1 дэд ангиллын автомашин, 18 ба түүнээс дээш нас
CE	Бүх жин нь 750 кг-аас их чиргүүлтэй холбосон С ангиллын автомашин, 18 ба түүнээс дээш нас
D1E	Бүх жин нь 750 кг-аас их чиргүүлтэй холбосон D1 дэд ангиллын автомашин, 18 ба түүнээс дээш нас
DE	Бүх жин нь 750 кг-аас их чиргүүлтэй холбосон D ангиллын автомашин (үүнд автобус болон троллейбус хамаарна), 18 ба түүнээс дээш насныхан

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН


Гарын үсэг /Signature/ *ОБ*

2026 оны 6 сарын 4 өдөр
 Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
 OFFICIAL TRANSLATION

Хавсралт В
Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газраас олгодог Олон улсын
жолоодох эрхийн үнэмлэх дэх тээврийн хэрэгслийн ангилал

Ангилал	Тээврийн хэрэгслийн ангилал
A	Хажуугийн чиргүүлтэй болон чиргүүлгүй мотоцикл, хөгжлийн бэрхшээлтэй хүний тээврийн хэрэгсэл, мөн хуурай жин нь 400 кг-аас (900 фунт) ихгүй гурван дугуйт механикжсан тээврийн хэрэгсэл
B	Жолоочоос гадна зорчигч тээвэрлэх зориулалттай, найм (8)-аас илүүгүй суудалтай тээврийн хэрэгсэл, эсхүл ачаа тээвэрлэх зориулалттай, бүх жин нь 3500 кг-аас (7700 фунт) хэтрэхгүй тээврийн хэрэгсэл. Энэ ангиллын тээврийн хэрэгсэлд хөнгөн чиргүүл багтаж болно.
C	Ачаа тээвэрлэх зориулалттай, бүх жин нь 3500 кг-аас (7700 фунт) их тээврийн хэрэгсэл. Энэ ангиллын тээврийн хэрэгсэлд хөнгөн чиргүүл багтаж болно.
D	Зорчигч тээвэрлэх зориулалттай, жолоочийн суудлаас гадна найм (8)-аас дээш суудалтай тээврийн хэрэгсэл. Энэ ангиллын тээврийн хэрэгсэлд хөнгөн чиргүүл багтаж болно.
E	Дээр зөвшөөрсөн B, C эсхүл D ангиллын тээврийн хэрэгсэл, хөнгөн чиргүүлээс бусад чиргүүлтэй бүрэлдэхүүн.




**Хавсралт С
Дүйцүүлэх хүснэгт**

1. Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхийг Бүгд Найрамдах Солонгос Улсын жолоодох эрхийн үнэмлэхтэй харилцан солилцох

БНСУ-н жолооны үнэмлэх			Монгол Улсын жолооны үнэмлэх
Нэгдүгээр ангилал	Том оврын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх		B, C1, D1
	Энгийн жолоодох эрхийн үнэмлэх		
	Тусгай үнэмлэх	Том оврын тээврийн хэрэгсэл чирэгч	
		Жижиг оврын тээврийн хэрэгсэл чирэгч	
Авто тээврийн түргэн тусламжийн тээврийн хэрэгсэл			
Хоёрдугаар ангилал	Энгийн		

2. Бүгд Найрамдах Солонгос Улсын жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхтэй харилцан солилцох

Монгол Улсын жолооны үнэмлэх	БНСУ-н жолооны үнэмлэх
B ангилал	Хоёрдугаар ангилал (энгийн)
C1 ангилал	
C ангилал	
D1 ангилал	
D ангилал	
BE ангилал	
C1E ангилал	
CE ангилал	
D1E ангилал	
DE ангилал	



몽골 정부와 대한민국 정부 간의
단기 방문자 운전
및
운전면허증 상호 인정과 교환에 관한 협정

몽골 정부와 대한민국 정부(이하 개별적으로 "체약당사자" 그리고 공동으로 "체약당사자들"이라 한다)는,

2021년에 수립된 체약당사자들 간의 전략적 동반자 관계를 상기하고,

양국 관계의 핵심축으로서 인적 교류를 증진하고 촉진하는 것의 중요성을 인식하며,

양국 국민의 공동 이익을 위하여 도로교통안전을 포함한 도로교통 분야에서 상호 관계를 강화하고 협력을 심화하기를 희망하며, 그리고

각자의 영역 내에서 도로교통을 효과적으로 원활하게 하고 국제운전면허증을 소지한 어느 한쪽 체약당사자의 단기 방문자가 다른 쪽 체약당사자의 영역 내에서 운전하는 것을 상호 인정하며, 체약당사자들의 권한 있는 당국이 발급한 국내운전면허증의 상호 인정 및 교환을 보장할 목적으로,

다음과 같이 합의하였다.

제1조

목적

이 협정의 목적은 국제운전면허증을 소지한 어느 한쪽 체약당사자의 단기 방문자가 다른 쪽 체약당사자의 영역 내에서 운전하는 체계와, 다른 쪽 체약당사자의 영역 내에서 1년을 초과하여 체류하는 사람들을 위한 체약당사자들의 권한 있는 당국이 발급한 국내

운전면허증의 상호 인정 및 교환을 위한 체계를 구축하는 것이다.

제2조

다른 쪽 체약당사자 영역 내에서의 단기 방문자의 운전

1. 각 체약당사자는 다른 쪽 체약당사자의 권한 있는 당국이 발급한 국제운전면허증을 인정하여 그러한 면허증 소지자가 다음과 같이 자동차를 운전할 수 있도록 허용한다.

가. 몽골 내에서, 대한민국 정부의 권한 있는 당국이 발급한 국제운전면허증을 소지한 대한민국 국민은 부속서 나에 규정된 국제운전면허증에 해당하는 범주에 따라 자동차를 운전하는 것이 허용된다.

나. 대한민국 내에서, 몽골 정부의 권한 있는 당국이 발급한 국제운전면허증을 소지한 몽골 국민은 부속서 가에 규정된 국제운전면허증에 해당하는 범주에 따라 자동차를 운전하는 것이 허용된다.

2. 운전할 수 있는 자동차의 범주는 국제운전면허증에 명시된 범주로 한정된다.

3. 국제운전면허증을 소지한 어느 한 쪽 체약당사자의 국민은 다른 쪽 체약당사자의 권한 있는 당국이 요청하는 경우 그러한 국제운전면허증을 여권과 함께 제시하는 것을 조건으로, 그 영역에 입국한 날부터 최대 1년 동안 다른 쪽 체약당사자의 영역 내에서 운전하는 것이 허용된다.

제3조

국내운전면허증의 교환

1. 계약당사자들은 국내운전면허증의 교환을 촉진할 목적으로, 다른 쪽 계약당사자의 권한 있는 당국이 발급한 유효한 국내운전면허증을 상호 인정한다. 국내운전면허증은 이 협정 부속서 다에 규정된 대응표에 따라 교환된다.

2. 이 협정의 규정에 따라, 18세 이상이고 다른 쪽 계약당사자의 영역 내에서 적법하게 1년을 초과하여 체류하고 있으며 유효한 국내운전면허증(임시 면허증 또는 연습 면허증 소지자는 제외한다)을 소지한 어느 한 쪽 계약당사자의 국민이 다른 쪽 계약당사자의 영역 내에서 자동차를 운전하기를 희망하는 경우, 다른 쪽 계약당사자의 권한 있는 당국은 그 국민이 제출한 신청에 기반하여 국내운전면허증의 교환을 허용한다.

3. 국내운전면허증의 교환은 신청자가 교환이 이루어지는 계약당사자의 관련 법령에 따라 요구되는 모든 수수료를 납부하고 신체검사를 통과할 것을 조건으로, 신청자가 자동차 운전 능력과 관련된 필기 및 실기 시험을 통과할 것을 요구하지 않고 실시된다.

4. 이 협정은 계약당사자들의 권한 있는 당국이 최초로 발급한 국내운전면허증에만 적용되며, 제3국에서 발급된 면허증을 교환하여 취득한 국내운전면허증에는 적용되지 않는다.

5. 이 조 제3항은 연령, 건강 상태 또는 정신 상태에 기반한 운전 제한과 관련된 각 계약당사자의 국내 법령에 영향을 미치지 아니한다.

제4조

교환 절차

1. 교환을 실시하는 계약당사자의 권한 있는 당국의 심사를 목적으로, 다른 쪽 계약 당사자의 신청자는 그 다른 쪽 계약당사자의 권한 있는 당국이 발급한 국내운전면허증 원본을, 요청을 받은 계약당사자의 공식 언어 또는 영어로 된 인증된 번역본과 함께 제출한다.

2. 국내운전면허증의 교환을 수행하는 계약당사자의 권한 있는 당국은 적용 가능한 국내 법령에 따라, 1961년 10월 5일 채택된 「외국공문서에 대한 인증의 요구를 폐지하는 협약」에 따라 교환을 위한 신청 전 1년 이내에 다른 쪽 계약당사의 관련 당국으로부터 발급받은 아포스티유를 포함한, 추가 서류의 제출을 요구할 수 있다.

3. 이 협정의 이행에 있어, 계약당사자들의 권한 있는 당국은 운전자 등록 및 행정 절차에 관한 그들 각자의 국내 법령을 적용할 수 있다.

제5조

면허증의 확인

1. 교환을 위하여 제출된 국내운전면허증의 유효성 및/또는 진위 여부에 의문이 있는 경우, 교환을 실시하는 권한 있는 당국은 다른 쪽 계약당사자의 권한 있는 당국에 국내운전면허증의 유효성 및/또는 진위 여부를 확인해 줄 것을 서면으로 요청할 수 있다.

2. 팩스, 전자우편 또는 그 밖의 전자적 수단으로 전송된 요청은 서면으로 제출된 것으로 간주한다.

3. 요청을 받은 체약당사자의 권한 있는 당국은 요청한 체약당사자의 권한 있는 당국에 그 국내운전면허증의 유효성 및/또는 진위 여부를 지체 없이 통지한다.

4. 확인을 위하여 필요한 경우, 요청을 받은 체약당사자의 권한 있는 당국은 요청한 체약당사자의 권한 있는 당국에 추가적인 정보를 요구할 수 있다.

제6조

권한 있는 당국

1. 이 협정의 목적을 위하여, 체약당사자들은 그들 각자의 권한 있는 당국을 다음과 같이 지정한다.

가. 몽골 정부의 경우, 몽골 법무내무부 산하 경찰청, 그리고

나. 대한민국 정부의 경우, 대한민국 경찰청

2. 이 협정의 발효에 앞서, 체약당사자들은 외교 경로를 통하여 다음 사항을 상호 제공한다.

가. 그들의 권한 있는 당국의 정식 명칭, 주소, 전화번호 및 팩스 번호, 전자우편 주소, 그리고

나. 이 협정이 적용되는, 그들의 국제운전면허증 및 국내운전면허증 견본과, 다른 쪽 체약당사자의 공식 언어 및 영어로 된 그 국내운전면허증의 인증된 번역본

3. 체약당사자들은 그들의 운전면허증의 변경(예를 들어, 그 견본의 변경), 이 협정의 이행에 영향을 미칠 수 있는 국내 법령의 변경 또는 개정, 그리고 그들의 권한 있는 당국의 연락처 정보 변경을 외교 경로를 통하여 서로에게 지체 없이 통지한다.

제7조

의사소통

이 협정에 따른 계약당사자들의 권한 있는 당국 간의 의사소통 및 외교 경로를 통한 계약당사자 간의 의사소통은 서면으로 수행되며, 다른 쪽 계약당사자의 공식 언어 또는 영어로 된 번역본을 수반한다.

제8조

다른 협정과의 관계

이 협정은 어느 한쪽 계약당사자가 당사국인 다른 국제 협정으로부터 발생하는 계약 당사자들의 권리와 의무에 영향을 미치지 아니한다.

제9조

협의

이 협정의 해석 또는 이행으로부터 발생하는 모든 이견은 계약당사자들의 권한 있는 당국 간의 협의를 통하여 해결된다. 그러한 이견이 권한 있는 당국에 의해 해결되지 못하는 경우, 외교 경로를 통하여 해결된다.

제10조

최종 규정

1. 이 협정은 체결당사자들이 이 협정의 발효에 필요한 그들 각자의 국내 법적 절차가 완료되었음을 외교 경로를 통하여 서로 통보하는 서면 통보 중 나중 통보를 접수한 날 후 여섯 번째 달의 첫째 날에 발효한다.

2. 이 협정은 무기한으로 효력을 가진다. 어느 한쪽 체결당사자는 외교 경로를 통하여 서면으로 통보함으로써 이 협정을 종료시킬 수 있다. 이 협정은 다른 쪽 체결당사자가 그러한 종료 통보를 접수한 날부터 90일 후에 종료된다.

3. 이 협정은 체결당사자들 간 상호 합의에 의하여 개정되거나 보충될 수 있다. 그러한 변경은 이 조 제1항에 규정된 절차에 따라 발효되는 의정서에 의해 공식화되며, 이 협정의 불가분의 일부를 구성한다.

이상의 증거로, 아래 서명자는 그들 각자의 정부로부터 정당하게 권한을 위임받아 이 협정에 서명하였다.

2026년 7월 9일 울란바타르에서 몽골어, 한국어 및 영어로 2부씩 작성하였으며, 모든 언어본은 동등하게 정본이다. 해석상 차이가 있을 경우 영어본이 우선한다.

몽골 정부를 대표하여

대한민국 정부를 대표하여

부속서 가

몽골 정부가 발급하는 국제운전면허증의 자동차 범주

구분	자동차 범주
A	이륜자동차(내연기관의 경우 실린더 용량이 50cc를 초과하거나, 전기모터의 경우 정격 출력이 4kW를 초과하고, 설계 최고 속도가 50km/h를 초과하는 모페드를 포함한 2륜 동력 차량), 만 18세 이상
B	운전석을 제외한 승차 정원이 8인 이하이고, 허용 최대 중량이 3,500kg 이하인 자동차(최대 중량이 750kg을 초과하지 아니하는 피견인차(트레일러)의 결합을 포함한다), 만 18세 이상
C1	허용 최대 중량이 7,500kg 이하인 C종 자동차(최대 중량이 750kg을 초과하지 아니하는 피견인차(트레일러)의 결합을 포함한다), 만 18세 이상
C	허용 최대 중량이 3,500kg을 초과하는 모든 자동차(D종은 제외한다)로, 최대 중량이 750kg을 초과하지 아니하는 피견인차(트레일러)와의 결합이 허용됨, 만 18세 이상
D1	운전석을 제외한 최대 승객 승차 정원이 16인 이하인 D종의 자동차로, 최대 중량이 750kg을 초과하지 아니하는 피견인차(트레일러)의 결합이 허용됨, 만 21세 이상
D	운전석을 제외하고 8석을 초과하는 승객 운송용 자동차로, 최대 중량이 750kg을 초과하지 아니하는 피견인차(트레일러)와의 결합이 허용됨, 만 21세 이상
BE	허용 최대 중량이 750kg을 초과하는 피견인차(트레일러)와 결합된 B종의 자동차, 만 18세 이상
C1E	허용 최대 중량이 750kg을 초과하는 피견인차(트레일러)와 결합된 C1종의 자동차, 만 18세 이상
CE	허용 최대 중량이 750kg을 초과하는 피견인차(트레일러)와 결합된 C종의 자동차, 만 18세 이상
D1E	허용 최대 중량이 750kg을 초과하는 피견인차(트레일러)와 결합된 D1종의 자동차, 만 18세 이상
DE	버스 및 트롤리버스를 포함한 허용 최대 중량이 750kg을 초과하는 피견인차(트레일러)와 결합된 D종의 자동차, 만 18세 이상

부속서 나

대한민국 정부가 발급하는 국제운전면허증의 자동차 범주

구분	자동차 범주
A	이륜자동차(측면 부착차의 유무를 불문), 신체장애인용 차량 및 차체 중량 400kg(900 lbs.)을 초과하지 않는 3륜 자동차
B	운전자의 좌석 이외에 최대 8개 좌석을 가진 승용차 및 허용 최대 중량이 3,500kg(7,700 lbs.)을 초과하지 않는 화물자동차. 1개의 소형 피견인차(트레일러)를 연결할 수 있음
C	허용최대중량이 3,500kg(7,700 lbs.)을 초과하는 화물자동차. 1개의 소형 피견인차(트레일러)를 연결할 수 있음
D	운전자의 좌석 이외에 8개 이상의 좌석을 가진 승용차. 1개의 소형 피견인차(트레일러)를 연결할 수 있음
E	상기 B종, C종 또는 D종 중 어느 하나에 해당하는 자동차로서 소형 피견인차(트레일러) 이외의 것을 연결한 것

부속서 다

대응표

1. 몽골 운전면허증의 대한민국 운전면허증으로의 상호 교환

대한민국 운전면허증			몽골 운전면허증
제1종	대형면허		B종, C1종, D1종
	보통면허		
	특수면허	대형견인	
		소형견인	
구난차			
제2종	보통면허		

2. 대한민국 운전면허증의 몽골 운전면허증으로의 상호 교환

몽골 운전면허증	대한민국 운전면허증
B종	제2종 보통면허
C1종	
C종	
D1종	
D종	
BE종	
C1E종	
CE종	

D1E종	
DE종	

AGREEMENT
BETWEEN
THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF KOREA
AND
THE GOVERNMENT OF MONGOLIA
ON DRIVING BY SHORT-TERM VISITORS AND
ON THE MUTUAL RECOGNITION AND EXCHANGE OF
DRIVING LICENSES

The Government of the Republic of Korea and the Government of Mongolia (hereinafter referred to individually as a “Contracting Party” and jointly as the “Contracting Parties”),

Recalling the Strategic Partnership between the Contracting Parties, established in 2021,

Recognizing the importance of promoting and facilitating people-to-people exchanges as a core pillar of the bilateral relationship,

Desiring to strengthen mutual relations and deepen cooperation in the field of road traffic, including road traffic safety, for the common benefit of the nationals of both countries, and

For the purpose of effectively facilitating road traffic within their respective territories, mutually accepting the driving by short-term visitors from one Contracting Party in the territory of the other Contracting Party with international driving permits, and ensuring the mutual recognition and exchange of domestic driving licenses issued by the competent authorities of the Contracting Parties,

Have agreed as follows:

Article 1

Purpose

The purpose of this Agreement is to establish a framework for the driving by short-term visitors from one Contracting Party in the territory of the other Contracting Party with international driving permits and for the mutual recognition and exchange of domestic driving licenses issued by the competent authorities of the Contracting Parties for persons who stay in the territory of the other Contracting Party for more than one (1) year.

Article 2

Driving by Short-Term Visitors in the Territory of the Other Contracting Party

1. Each Contracting Party shall recognize international driving permits issued by the competent authority of the other Contracting Party to allow holders of such permits to drive motor vehicles as follows:

(a) in Mongolia, nationals of the Republic of Korea who hold an international driving permit issued by the competent authority of the Government of the Republic of Korea shall be permitted to drive motor vehicles according to the category corresponding to such international driving permit as specified in Annex B; and

(b) in the Republic of Korea, nationals of Mongolia who hold an international driving permit issued by the competent authority of the Government of Mongolia shall be permitted to drive motor vehicles according to the category corresponding to such international driving permit as specified in Annex A.

2. The types of motor vehicles that may be driven shall be limited to those specified in international driving permits.

3. The nationals of one Contracting Party holding international driving permits shall be allowed to drive in the territory of the other Contracting Party for a period of up to one (1) year from the date of entering that territory, provided that such international driving permit shall, when requested by the competent authority of that other Contracting Party, be presented, together

with a passport.

Article 3

Exchange of Domestic Driving Licenses

1. The Contracting Parties shall, for the purpose of facilitating exchange of domestic driving licenses, mutually recognize valid domestic driving licenses issued by the competent authorities of the other Contracting Party. Domestic driving licenses shall be exchanged in accordance with the Table of Equivalence specified in Annex C of this Agreement.

2. In accordance with the provisions of this Agreement, whenever a national of one Contracting Party—who is at least eighteen (18) years of age, is lawfully staying in the territory of the other Contracting Party for more than one (1) year, and holds a valid domestic driving license (excluding holders of temporary or learner's permits)—wishes to drive a motor vehicle in the territory of that other Contracting Party, the competent authorities of that other Contracting Party shall allow the exchange of the domestic driving license based on the request submitted by that national.

3. The exchange of domestic driving licenses shall be conducted without requiring the applicant to pass theoretical and practical driving tests related to the ability to drive a motor vehicle, provided that the applicant shall pay all required fees and pass a physical examination under the relevant laws and regulations of the Contracting Party where the exchange takes place.

4. This Agreement shall apply only to domestic driving licenses originally issued by the competent authorities of the Contracting Parties and shall not apply to domestic driving licenses obtained by exchanging a license issued by a third country.

5. Paragraph 3 of this Article shall not affect the domestic laws and regulations of each Contracting Party concerning driving restrictions based on age, health conditions, or mental state.

Article 4
Exchange Procedures

1. For the purpose of examination by the competent authority of the Contracting Party performing the exchange, an applicant from the other Contracting Party shall submit the original domestic driving license issued by the competent authority of that other Contracting Party, accompanied by a certified translation in the official language of the requested Contracting Party or in English.

2. The competent authority of a Contracting Party carrying out an exchange of domestic driving licenses may require the submission of any further documents in accordance with the applicable domestic laws and regulations, including an Apostille issued by the relevant authority of the other Contracting Party within one (1) year prior to the application for exchange, in accordance with the Convention Abolishing the Requirement of Legalisation for Foreign Public Documents done on 5 October 1961.

3. In the implementation of this Agreement, the competent authorities of the Contracting Parties may apply their respective domestic laws and regulations concerning driver registration and administrative procedures.

Article 5
Verification of Licenses

1. In case of doubt as to the validity and/or authenticity of a domestic driving license submitted for exchange, the competent authority performing the exchange may request the competent authority of the other Contracting Party, in writing, to verify the validity and/or authenticity of the domestic driving license in question.

2. Requests transmitted by facsimile, email, or other electronic means shall be deemed to have been submitted in writing.

3. The competent authority of the requested Contracting Party shall inform the competent authority of the requesting Contracting Party of the validity and/or authenticity of that domestic driving license without undue delay.

4. Where necessary for verification, the competent authority of the requested Contracting Party may require supplementary information from the competent authority of the requesting Contracting Party.

Article 6

Competent Authorities

1. For the purposes of this Agreement, the Contracting Parties shall designate their respective competent authorities as follows:

(a) for the Government of Mongolia, the National Police Agency under the Ministry of Justice and Home Affairs of Mongolia; and

(b) for the Government of the Republic of Korea, the Korean National Police Agency.

2. Prior to the entry into force of this Agreement, the Contracting Parties shall provide each other through diplomatic channels, with the following:

(a) the full names, addresses, telephone and facsimile numbers, and email addresses of their competent authorities; and

(b) specimens of their international driving permits and domestic driving licenses to which this Agreement applies, accompanied by certified translations of such domestic driving licenses in the official language of the other Contracting Party and in English.

3. The Contracting Parties shall promptly inform each other through diplomatic channels of any changes to their driving licenses (for example, changes to the specimens thereof), any changes or amendments to domestic laws and regulations that may affect the implementation

of this Agreement, and any changes to the contact information of their competent authorities.

Article 7
Communications

Communications between the competent authorities of the Contracting Parties and communications between the Contracting Parties through diplomatic channels under this Agreement shall be conducted in writing and accompanied by the translations in the official language of the other Contracting Party or in English.

Article 8
Relationship with Other Agreements

This Agreement shall not affect the rights and obligations of the Contracting Parties arising from other international agreements to which either Contracting Party is a party.

Article 9
Consultations

Any differences arising from the interpretation or implementation of this Agreement shall be resolved through consultations between the competent authorities of the Contracting Parties. In the event that such differences cannot be resolved by the competent authorities, they shall be settled through diplomatic channels.

Article 10
Final Provisions

1. This Agreement shall enter into force on the first day of the sixth month following the date of receipt of the later written notification through diplomatic channels by which the Contracting Parties notify each other that their respective internal legal procedures necessary for the entry into force of this Agreement have been completed.

2. This Agreement shall be in force for an indefinite period. Either Contracting Party may terminate this Agreement by giving written notice through diplomatic channels. This Agreement shall terminate on the ninetieth (90th) day after the date on which the other Contracting Party receives such notification of termination.

3. This Agreement may be amended or supplemented by mutual agreement between the Contracting Parties. Such changes shall be formalized by protocols entering into force in accordance with the procedure prescribed in Paragraph 1 of this Article and shall form an integral part of this Agreement.

IN WITNESS WHEREOF, the undersigned, being duly authorized by their respective governments, have signed this Agreement.

DONE in duplicate at [Place], on this [Day] day of [Month], 20__, in the Korean, Mongolian, and English languages, all texts being equally authentic. In case of any divergence of interpretation, the English text shall prevail.

FOR THE GOVERNMENT
OF THE REPUBLIC OF KOREA

FOR THE GOVERNMENT
OF MONGOLIA

Annex A

Categories of Vehicles in International Driving Permits Issued by the Government of Mongolia

Category	Category of Vehicles
A	Motorcycles (two-wheeled mechanized vehicles with a cylinder capacity exceeding 50cc for internal combustion engines or a rated power exceeding 4kW for electric motors, and a design maximum speed exceeding 50km/h, including mopeds), Age 18 and over
B	Motor vehicles with a seating capacity of not more than 8 persons excluding the driver's seat, and a maximum permissible weight not exceeding 3,500kg (including a coupled trailer with a maximum weight not exceeding 750kg), Age 18 and over
C1	Vehicles of Category C with a maximum permissible weight not exceeding 7,500kg (including a coupled trailer with a maximum weight not exceeding 750kg), Age 18 and over
C	All motor vehicles with a maximum permissible weight exceeding 3,500kg (excluding Category D), allowed to couple with a trailer with a maximum weight not exceeding 750kg, Age 18 and over
D1	Vehicles of Category D with a maximum passenger seating capacity of not more than 16 persons excluding the driver's seat, allowed to couple a trailer with a maximum weight not exceeding 750kg, Age 21 and over
D	Motor vehicles for the carriage of passengers with more than 8 seats excluding the driver's seat, allowed to couple with a trailer with a maximum weight not exceeding 750kg, Age 21 and over
BE	Category B vehicles coupled with a trailer having a maximum permissible weight exceeding 750kg, Age 18 and over
C1E	Category C1 vehicles coupled with a trailer having a maximum permissible weight exceeding 750kg, Age 18 and over
CE	Category C vehicles coupled with a trailer having a maximum permissible weight exceeding 750kg, Age 18 and over
D1E	Category D1 vehicles coupled with a trailer having a maximum permissible weight exceeding 750kg, Age 18 and over
DE	Category D vehicles coupled with a trailer having a maximum permissible weight exceeding 750kg, including buses and trolleybuses, Age 18 and over

Annex B

Categories of Vehicles in International Driving Permits Issued by the Government of the Republic of Korea

Category	Category of Vehicles
A	Motor cycles, with or without a side-car, invalid carriages and three-wheeled motor vehicles with an unladen weight not exceeding 400 kg.(900 lbs.).
B	Motor vehicles used for the transport of passengers and comprising, in addition to the driver's seat, at most eight seats, or those used for the transport of goods and having a permissible maximum weight not exceeding 3,500 kg.(7,700 lbs.). Vehicles in this category may be coupled with a light trailer.
C	Motor vehicles used for the transport of goods and of which the permissible maximum weight exceeds 3,500 kg.(7,700 lbs.). Vehicles in this category may be coupled with a light trailer.
D	Motor vehicles used for the transport of passengers comprising, in addition to the driver's seat, more than eight seats. Vehicles in this category may be coupled with a light trailer.
E	Motor vehicles of categories B, C or D, as authorized above, with other than a light trailer.

Annex C

Table of Equivalence

1. Mutual Exchange of Mongolian Driving Licenses for Republic of Korea Driving Licenses

Republic of Korea Driving License		Mongolian Driving License
Class 1	Large vehicle driving license	
	Ordinary license	
	Special license	Large vehicle trailer
		Small vehicle trailer
Emergency vehicle		
Class 2	Ordinary	

2. Mutual Exchange of Republic of Korea Driving Licenses for Mongolian Driving Licenses

Mongolian Driving License	Republic of Korea Driving License
Category B	Class 2 (Ordinary)
Category C1	
Category C	
Category D1	
Category D	
Category BE	
Category C1E	
Category CE	
Category D1E	
Category DE	

“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН БОГИНО ХУГАЦААНЫ ЗОРЧИГЧДЫН
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ БОЛОН ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХИЙГ
ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, СОЛИЛЦОХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ
БАЙГУУЛСНААР МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ ҮР, НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ДҮН
ШИНЖИЛГЭЭ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь 2021 онд харилцаагаа “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэн өргөжүүлсэн бөгөөд тус түншлэлийн хүрээнд тодорхойлсон харилцааны үндсэн таван тулгуур чиглэлийн нэг нь соёл, аялал жуулчлал, иргэд хоорондын харилцаа, солилцоог хөгжүүлэх, өргөжүүлэх зорилтыг тусгасан байдаг.

Энэхүү зорилтын хүрээнд Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улсын хоорондын түүх, соёлын хэлхээ холбоо нь хоёр улсын харилцааны хөгжлийн чухал суурь болж ирснийг тэмдэглэж, ард түмэн хоорондын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх зорилгоор соёлын хамтын ажиллагаа болон иргэд хоорондын солилцоог өргөжүүлэхээр тохиролцсон.

Иймд хоёр улсын иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, харилцан зорчих урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь дээрх зорилтын биелэлтийг хангахад чухал ач холбогдолтой юм. Энэ хүрээнд байгуулах “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын богино хугацааны зорчигчдын тээврийн хэрэгсэл жолоодох болон жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох тухай хэлэлцээр” нь хоёр улсын иргэдийн харилцан зорчих, ажиллах, суралцах болон аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих, тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой зохицуулалтыг хялбаршуулахад чиглэсэн чухал алхам болж байгаа юм.

Одоогоор БНСУ-д манай улсын 60 гаруй мянган иргэн оршин сууж, суралцаж, хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд хоёр орны хооронд аялал жуулчлал, бизнесийн зорилгоор харилцан зорчигчдын тоо тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал Гадаад харилцааны яамны Консулын газраас 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдөр гаргасан статистик мэдээллээр БНСУ-д богино хугацаагаар зорчсон Монгол иргэдийн тоо 2022 онд 67,146, 2023 онд 141,638, 2024 онд 150,201, 2025 онд 161,755 болж жил бүр нэмэгдсэн байна. Түүнчлэн Монгол Улсад зорчсон БНСУ-ын иргэдийн тоо 2022 онд 52,793 байсан бол 2025 онд 162,971-д хүрч, мөн өссөн үзүүлэлттэй байна.

Гэхдээ Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцын гишүүн бус орноос олгогдсон жолоочийн болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр Монгол Улсын нутаг дэвсгэрт механикжсан тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно” гэж заасан байдаг. Энэхүү зохицуулалтын дагуу Монгол Улс

нь 1968 оны Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцын гишүүн 90 гаруй орноос олгосон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг.

Харин БНСУ нь уг конвенцод нэгдэн ороогүй тул тус улсын иргэдийн олон улсын жолоодох эрхийн үнэмлэх Монгол Улсын нутаг дэвсгэрт шууд хүлээн зөвшөөрөгдөх эрх зүйн үндэслэлгүй байна. Үүнтэй адил манай улсын иргэд БНСУ-д богино хугацаагаар зорчих үедээ олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээ ашиглах боломжгүй байдаг тул энэхүү харилцааг тусгайлсан хоёр талт хэлэлцээрээр зохицуулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцтой холбоотой дээрх эрх зүйн зохицуулалтын улмаас БНСУ-ын иргэд Монгол Улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах, эсхүл өөрсдийн үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг солиулахдаа манай улсын холбогдох журмын дагуу нэмэлт шалгалт, шаардлагыг хангах үүрэг хүлээдэг. Одоогийн байдлаар Монгол Улсад БНСУ-ын 2,240 иргэн жолоодох эрхийн үнэмлэх авснаас 1,046 нь хүчинтэй, 1,187-ийнх нь хугацаа дууссан, 7 иргэний жолоодох эрх хасагдсан бүртгэлтэй байна. Жилд дунджаар БНСУ-ын 39-49 иргэн жолоодох эрх авахтай холбоотой онолын шалгалтад хамрагддаг бөгөөд тэдгээрийн 64.9 хувь нь тэнцэж, үлдсэн хэсэг нь хэлний бэрхшээл болон шалгалтын материалын орчуулгатай холбоотой хүндрэлээс шалтгаалан тэнцдэггүй байна.

Нөгөө талаас, БНСУ-д богино хугацаагаар оршин сууж, хөдөлмөр эрхэлж буй манай улсын иргэдийн хувьд ч тус улсын “Замын хөдөлгөөний тухай хууль”-ийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтад заавал хамрагдах, онолын болон жолоодлогын ур чадварын шалгалт өгөх, эрүүл мэндийн үзлэгт орох зэрэг шат дараалсан нөхцөлүүдийг биечлэн хангах шаардлага тулгардаг нь иргэдэд цаг хугацаа, санхүүгийн багагүй чирэгдэл үүсгэдэг байна.

Статистик мэдээллээс үзэхэд БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдийн хувьд жил бүр дунджаар 3,000 орчим хүн тус улсын жолоодох эрхийн шалгалтад хамрагддаг бөгөөд 2025 онд энэ тоо 3,300-д хүрсэн байна. Мөн 2024 оны байдлаар БНСУ-д манай улсын 1,249 иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдсоноос нийт зөрчлийн 25 хувь буюу 313 тохиолдол нь жолоодох эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодох, жолооны ангилал зөрчих, түүнчлэн бүртгэлгүй болон даатгалгүй тээврийн хэрэгсэл ашигласан зөрчлүүд эзэлсэн байна.

“Монгол Улсын Загсийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын богино хугацааны зорчигчдын тээврийн хэрэгсэл жолоодох болон жолоодох эрхийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, солилцох тухай хэлэлцээр” батлагдсанаар гарах үр дүнгүүд:

- Хэлэлцээрийн хүрээнд хоёр улсын богино хугацааны зорчигчид нөгөө талын нутаг дэвсгэрт нэг жил хүртэлх хугацаанд өөрийн олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг харилцан хүлээн зөвшөөрөх юм.
- Нэг жил буюу түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор оршин суугаа хоёр улсын иргэд онолын болон жолоодлогын нэмэлт шалгалт өгөхгүйгээр, өөрсдийн үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг нөгөө талын жолоодох эрхийн үнэмлэхээр шууд солиулах эрх зүйн зохицуулалт бүрдэнэ.
- Хоёр улсын нутаг дэвсгэрт богино хугацаагаар зорчиж буй иргэд олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээ шууд ашиглах боломжтой болсноор тухайн улсад дахин шалгалт өгөх, шинээр жолоодох эрхийн үнэмлэх авах шаардлагагүй болж, иргэдийн цаг хугацаа, санхүүгийн зардлыг бууруулна.
- Манай улсын Цагдаагийн ерөнхий газар болон БНСУ-ын Үндэсний цагдаагийн газар хооронд мэдээлэл солилцох тогтолцоо бий болсноор жолоодох эрхийн мэдээллийг харилцан шалгах, баталгаажуулах боломж сайжирч, хуурамч үнэмлэх ашиглах болон жолоодох эрхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэж, хоёр улсын нутаг дэвсгэр дэх замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоо сайжирна.

ХЭЛЭЛЦЭЭРИЙН ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар Монгол Улс, БНСУ-ын Стратегийн түншлэлийн хүрээнд иргэд хоорондын солилцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болно. Ялангуяа хилийн чанадад амьдарч буй Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний өдөр тутмын амьдралд тулгардаг практик хүндрэлийг Засгийн газрын төвшинд шуурхай шийдвэрлэх боломж бүрдэж байна.

Түүнчлэн хэлэлцээр хэрэгжсэнээр БНСУ нь 1968 оны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Венийн конвенцод нэгдэн ороогүй учраас жолоодох эрхийн үнэмлэхийг шууд хүлээн зөвшөөрөх боломжгүй нөхцөлийг эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэж, хоёр улсын иргэд харилцан нөгөө улсын нутаг дэвсгэрт хууль ёсны дагуу тээврийн хэрэгсэл жолоодох боломж бүрдэнэ.

Үүнээс гадна хоёр улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжиж, жолоочийн мэдээлэл, жолоодох эрхийн ангилал, хүчинтэй байдлыг харилцан шалгах боломж бүрдсэнээр

хяналтын тогтолцоо боловсронгуй болох юм. Энэ нь жолоочийн хариуцлагын тогтолцоог сайжруулах, замын хөдөлгөөний зөрчилтэй тэмцэх, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой.

Жолоодох эрхийн зохицуулалтыг хялбаршуулснаар хоёр улсын иргэдийн харилцан зорчих нөхцөл сайжирч, БНСУ-д ажиллаж, суралцаж буй Монгол Улсын иргэд болон Монгол Улсад зорчиж буй БНСУ-ын иргэдийн тээврийн хэрэгсэл ашиглах боломж нэмэгдэнэ. Энэ нь хоёр улсын иргэд хоорондын харилцаа, аялал жуулчлал, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

oooOooo